



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/517

Арвайхээр

### Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтын 2.39, аймгийн Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 165 дугаар захирамжаар батлагдсан “Нэрэмжит шагналын журам”, аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн а/788 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журмыг шинэчлэн батлах тухай” журмын 2.4, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шинэчлэлийн бодлого, шүүхийн багц хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж ажлын амжилт гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн ёс зүйн хорооны гишүүн Баясахын Сугар (ЙЮ79030937)-ыг “Төрийн шилдэг түшээ” тэмдгээр, мөн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний түүхт 90 жил, “Онги-Ус суваг” ОНӨААТҮГ-ын 85 жилийн ойг тохиолдуулан үр бүтээлтэй ажиллаж буй тус газрын ахлах операторчин Лхасүрэнгийн Жаргалсайхан (ЙК89651219), усан сангийн харуул, операторч Аюурзанын Бат-Эрдэнэ (ЙК68110515), станцын операторч, харуул Оюунчимэгийн Ууганбаатар (ЙЮ88062798) нарыг “Аймгийн Засаг даргын жуух бичиг”-ээр тус тус шагнасугай.

2. Журмын дагуу “Төрийн шилдэг түшээ” шагналд дагалдах 200.000 (хоёр зуун мянга), Засаг даргын жуух бичигт дагалдах тус бүр 30.000 (гучин мянга), нийт 290.000 (хоёр зуун ерэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101096